



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/362

Хэрлэн сум

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн өдөр
зарим үйл ажиллагааг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль зохион байгуулагдахтай холбогдуулан Батноров, Батширээт, Бор-Өндөр, Дархан, Дэлгэрхаан, Норовлин сумдад 2025 оны 06 дугаар сарын 21-ээс 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрүүдэд согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэхийг, 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллахыг тус тус хориглосугай.

2. Энэхүү захирамжийг аж ахуйн нэгж, иргэд, олон нийтэд мэдээлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батноров, Батширээт, Бор-Өндөр, Дархан, Дэлгэрхаан, Норовлин сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ



